



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

“Масдак ҮЦК” ХХК-ийн арилжаанд
оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 298 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан “Масдак ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Масдак ҮЦК” ХХК /В.Баттулга/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын алба /Д.Баттулга/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ